

**“ЦАГААН ТОЛГОЙ” ХУВЬЦААТ КОМПАНИ**

**ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН**  
**2020 он**

**Сэлэнгэ аймаг**

## **1. Компаний танилцуулга**

Цагаантолгой ХК нь газар тариалан, мал аж ахуй, зочид буудал, зоогийн газрын үйлчилгээ, гурилын үйлдвэрлэл, хүнсний төрөлжсөн дэлгүүрийн жижиглэн худалдааны үйл ажиллагаа эрхлэн явуулах зорилгоор 1995 онд анх үүсгэн байгуулагдсан ба голлох хувьцаа эзэмшигчидийн бүрэлдэхүүнд өөрчлөлт орсонтой холбоотойгоор 2013 оны улсын бүртгэлийн хуулийн этгээдийн нэгдсэн тооллогод бүртгүүлж 11,081.3 мянган төгрөгийн хөрөнгө оруулалттайгаар үйл ажиллагаа явуулж байна. Компаний хуучин эрхэлж байсан үйл ажиллагаанаас гадна бизнесийн консалтинг, гадаад худалдааны чиглэлээр түлхүү үйл ажиллагаа эрхлэх зорилгоор тодорхой бизнес төслүүдийг эхлэхээр төлөлж байгаа боловч Монгол улсын гадаад хөрөнгө оруулалтын орчин, эдийн засгийн нөхцөл байдал, дэлхий дахинд дэгдээд буй цар тахалтай холбоотойгоор түр хугацаанд хойшлуулсан байдалтай байна.

## **2. Хаяг:**

Сэлэнгэ аймаг Сант, 2-р баг, Хашаат, 1, 1-27 тоот, Утас: (+976) – 99788501

## **3. Үйл ажиллганы тайлан**

Компани нь хэдийгээр Монгол улсын гадаад хөрөнгө оруулалтын орчин, эдийн засгийн нөхцөл байдал, дэлхий дахинд дэгдээд буй цар тахалтай холбоотойгоор 2020 онд идэвхитэй үйл ажиллагаа явуулаагүй боловч гадаад худалдаа, бизнес консалтингийн үйлчилгээний чиглэлээр тодорхой судалгааны ажлуудийг хийж гүйцэтгэсэн.

## **4. Нөлөө бүхий хувьцаа эзэмшигчид**

1	ЭРДЭНЭБАЯР ЯНЖИНЛХАМ	27.77 %
2	АМГАЛАН ЧИМГЭЭ	55.53 %

## **5. Ногдол ашиг**

Цагаантолгой ХК нь 2020 онд идэвхитэй үйл ажиллагаа явуулаагүй тул 2021 оны 2 сарын 10-ны өдрийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хурлын 1/0 тоот тогтоолоор ногдол ашиг хуваарилахгүй шийдвэр гаргасан болно.

## **6. Санхүүгийн мэдээлэл**



АУДИТ  
БАТАЛГААЖУУЛАЛТ  
ҮЙЛЧИЛГЭЭ

Монголиан Бизнес Рейтинг Аудит ХХК  
УБ, Баянзүрх дүүрэг, 6-р хороо  
Барилга.МН ХХК-ийн оффис 303  
Утас: 976-7000-5329  
Гар утас: 976-9985-1823  
И-мэйл: mbr.audit.lc@gmail.com

---

## ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

---

### **“ЦАГААН ТОЛГОЙ” ХК-НЫ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДЭД**

#### ***Зөрчилгүй дүгнэлт***

“Цагаан толгой” ХК (цаашид компани гэх)-ын 2020 оны 12 дугаар сарын 31-ний санхүүгийн байдлын тайлан, уг өдрөөр тасалбар болгосон тайлант жилийн орлогын тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан болон нягтлан бодох бүртгэлийн бодлого, тайлбар тодруулгаас бүрдсэн санхүүгийн тайланд аудит хийлээ.

“Цагаан толгой” ХК-ийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн болон мөнгөн гүйлгээг бүх материаллаг зүйлсийн хувьд Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (цаашид СТОУС гэх), түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан журмуудын дагуу үнэн, шударгаар илэрхийлж байна гэж дүгнэж байна.

#### ***Зөрчилгүй дүгнэлтийн үндэслэл***

Бид аудитаа Аудитын олон улсын стандарт (цаашид АУОС гэх)-ын дагуу хийж гүйцэтгэсэн болно. Уг стандартуудын дагуу бидний хүлээх үүргийг энэхүү тайлангийн Санхүүгийн Тайлангийн аудиттай холбоотой Аудиторын үүрэг хэсэгт тусгасан. Бид Нягтлан Бодогчийн Ёс Зүйн Олон Улсын Стандартын Зөвлөлөөс баталсан Мэргэжлийн нягтлан бодогчийн ёс зүйн дүрэм (цаашид “НБЁЗОУСЗ-ын дүрэм” гэх)-ийн дагуу тус байгууллагаас хараат бус, бусад ёс зүйн үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн болно. Бидний олж авсан аудитын нотолгоо нь аудитын дүгнэлт гаргах хангалттай бөгөөд зохистой үндэслэл болно гэж итгэж байна.

#### ***Аудитын гол асуудлууд***

Бидний мэргэжлийн үнэлэмжээр аудитын гол асуудлууд нь тайлант жилийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал асуудал юмаа. Санхүүгийн тайланд хийсэн аудитынхаа хүрээнд эдгээр асуудлуудыг авч үзсэн ба дүгнэлт гаргахдаа эдгээр асуудлуудад тус тусад нь дүгнэлт гаргаагүй болно

#### ***Татварын тооцооллын үнэн зөв байдал***

Татварын өр төлбөрийн тооцоололт болон татварын хууль тогтоомжийн хэрэгжүүлэлт нь үнэлэмж шаарддаг учраас бид татварын тооцооллын үнэн, зөв байдлыг аудитын гол асуудал гэж үзсэн.

Зах зээлийн эдийн засагт шилжих шилжилттэй холбоотойгоор Монгол улсын Засгийн газар бизнес болон эдийн засгийн бүтцэд өөрчлөлт хийсээр байна. Үүний үр дүнд бизнесийн үйл ажиллагаанд нөлөө үзүүлэх хууль журмууд ч мөн өөрчлөгдсөөр байна.

Эрх бүхийн өөр өөр байгууллагууд татварын хуулийн хэрэгжилтэд хяналт шалгалт хийж төлбөр торгууль тавих хуулиар тогтоосон эрхтэй байдаг. Татварын хууль тогтоомжийн ойлголт дээр үндэслэн бүх татварыг үнэн зөв тодорхойлсон гэж итгэж байгаа боловч дээр дурдсан хүчин зүйлүүдээс үндэслэн компанид татварын эрсдэл байсаар байна.

---

## ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ (үргэлжлэл)

---

### **Бусад мэдээлэл**

Удирдлага нь бусад мэдээллийн талаар үүрэг хүлээнэ. Бусад мэдээлэл нь жилийн тайланд багтсан хэдий ч санхүүгийн тайлан ба аудиторын тайланд багтаагүй мэдээллээс бүрдэнэ.

Энэхүү санхүүгийн тайланд өгөх бидний дүгнэлт нь бусад мэдээллийг хамраагүй бөгөөд бид бусад мэдээлэлд ямар нэгэн дүгнэлт өгөхгүй.

Санхүүгийн тайлангийн аудиттай холбоотойгоор бид бусад мэдээллийг бэлэн болсон үед унших үүрэгтэй бөгөөд, бусад мэдээлэл нь санхүүгийн тайлан эсвэл аудитын явцад цуглуулсан мэдээллээс материаллаг хэмжээний алдаатай эсэхийг авч үзэх ёстой.

Бусад мэдээллийг уншиж, бусад мэдээлэл нь материаллаг хэмжээний зөрүүтэй эсвэл алдаатай байвал бид засаглах эрх бүхий этгээдэд мэдэгдэх үүрэгтэй бөгөөд, бид бусад горимыг гүйцэтгэж, бусад мэдээлэл материаллаг хэмжээний алдаа байгаа гэж үзсэн ба түүнийг залруулаагүй бол, залруулаагүй материаллаг хэмжээний алдааг манай тайлангийн мэдээлэл хэрэглэгчдэд хүргэхийн тулд бид зохистой арга хэмжээ авахыг засаглах эрх бүхий этгээдээс хүсэх болно.

Хэрэв бид компанийн аудит хийсэн санхүүгийн тайлан, байгууллагын орчны талаарх бидний ойлголтод материаллаг хэмжээний алдаа байна гэж үзвэл, бид АОУС-ын дагуу холбогдох арга хэмжээ авна.

### **Санхүүгийн Тайлантай холбоотой Удирдлага болон Засаглах Эрх Бүхий Этгээдийн Үүрэг**

Санхүүгийн тайлангуудыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэн шударгаар илэрхийлэх, санхүүгийн тайланг алдаа эсвэл санаатай зальт үйлдлээс үүсэлтэй материаллаг хэмжээний алдаагүйгээр бэлтгэж, шударгаар илэрхийлэхийн тулд удирдлагаас шаардлагатай гэж тогтоосон дотоод хяналтыг хэрэгжүүлэх үүрэгтэй

Санхүүгийн тайланг бэлтгэхдээ компанийг татан буулгах, үйл ажиллагааг нь зогсоох, эсвэл үүнээс өөр боломжит сонголт байхгүй байхаас бусад тохиолдолд удирдлага байгууллагын үйл ажиллагаагаа тасралтгүй явуулах чадамжийг үнэлэх, тодруулах, нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг ашиглан санхүүгийн тайланг бэлтгэх үүрэгтэй.

Засаглах эрх бүхий этгээд нь компанийн санхүүгийн тайлангийн үйл явцад хяналт тавих үүрэгтэй.

### **Санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой Аудиторын үүрэг**

Санхүүгийн тайлан нь бүхэлдээ алдаа, эсвэл санаатай зальт үйлдлийн улмаас материаллаг хэмжээний алдаагүй илэрхийлэгдсэн эсэх талаар ул үндэслэлтэй нотолгоо олж авах болон бидний дүгнэлтийг агуулсан аудиторын тайлан гаргах нь бидний зорилго юм. Ул үндэслэлтэй нотолгоо гэдэг нь өндөр түвшний нотолгоо боловч АОУС-ын дагуу хийгдсэн аудит нь байнга материаллаг хэмжээний алдааг илрүүлдэг гэсэн баталгаа болохгүй. Алдаатай илэрхийлэл нь алдаа эсвэл санаатай зальт үүдлээс үүсэж болох ба дангаараа эсвэл нийтдээ санхүүгийн



АУДИТ  
БАТАЛГААЖУУЛАЛТ  
ҮЙЛЧИЛГЭЭ

Монголиан Бизнес Рейтинг Аудит ХХК  
УБ, Баянзүрх дүүрэг, 6-р хороо  
Барилга.МН ХХК-ийн оффис 303  
Утас: 976-7000-5329  
Гар утас: 976-9985-1823  
И-мэйл: mbr.audit.llc@gmail.com

## ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ (үргэлжлэл)

тайланд үндэслэн шийдвэр гаргах санхүүгийн тайлангийн хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх магадлалтай бол материаллаг гэж үздэг.

### *Тайлангийн хэрэглээ*

Бид энэхүү тайланг хуулийн этгээд болох "Цагаан толгой" ХК-ийн удирдах зөвлөлд зориулж бэлтгэсэн. Бид энэхүү тайлангийн агуулгын хүрээнд өөр аливаа нэг гуравдагч талын өмнө хариуцлага хүлээхгүй.



Д.Түмэнхаргал, Д.Түмэнхаргал,  
Монголиан Бизнес Рейтинг Аудит ХХК  
Улаанбаатар хот, Монгол Улс

Огноо: 2021.02.22

**“ЦАГААН ТОЛГОЙ” ХК**  
**2020 оны 12-р сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн**

**САНХҮҮ БАЙДЛЫН ТАЙЛАН**

Үзүүлэлт	Тод	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>ХӨРӨНГӨ</b>			
<b>Эргэлтийн хөрөнгө</b>			
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	3	1,392.0	89.0
Татвар, НДШ – ийн авлага	4	150.0	150.0
<b>Эргэлтийн хөрөнгийн дүн</b>		<b>1,542.0</b>	<b>239.0</b>
<b>Эргэлтийн бус хөрөнгө</b>			
Үндсэн хөрөнгө	5	11,081.3	11,081.3
<b>Эргэлтийн бус хөрөнгийн дүн</b>		<b>11,081.3</b>	<b>11,081.3</b>
<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>		<b>12,623.3</b>	<b>11,320.3</b>
<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>			
Дансны өглөг	6	13,901.8	23,151.4
Татварын өр	6	-	289.0
НДШ - ийн өглөг	6	-	364.0
<b>Богино хугацаат өр төлбөрийн дүн</b>		<b>13,901.8</b>	<b>23,804.4</b>
<b>УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>			
<b>Урт хугацаат өр төлбөрийн дүн</b>		<b>-</b>	<b>-</b>
<b>Өр төлбөрийн нийт дүн</b>		<b>13,901.8</b>	<b>23,804.4</b>
<b>ЭЗДИЙН ӨМЧ</b>			
<b>Өмч</b>		<b>11,081.3</b>	<b>11,081.3</b>
-хувьцаат	7	11,081.3	11,081.3
Хуримтлагдсан ашиг	7	-12359.8	-23,565.4
<b>Эздийн өмчийн дүн</b>		<b>-1,278.5</b>	<b>-12,484.1</b>
<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН</b>		<b>12,623.3</b>	<b>11,320.3</b>

**“ЦАГААН ТОЛГОЙ” ХК**

**2020 оны 12-р сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн**

**ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН**

<b>№</b>	<b>Үзүүлэлт</b>	<b>Тод</b>	<b>Өмнөх оны</b>	<b>Тайлант оны</b>
1	Борлуулалтын орлого (цэвэр)	11	-	-
2	Борлуулалтын өртөг		-	-
3	<b>Нийт ашиг ( алдагдал)</b>		-	-
4	Хүүний орлого		-	-
5	Бусад орлого		-	-
6	Ерөнхий ба удирдлагын зардал	13	1,221.0	11,205.6
8	Бусад зардал	14	-	-
9	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	12	-	-
10	<b>Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)</b>		<b>-1,221.0</b>	<b>-11,205.6</b>
11	Орлогын татварын зардал	15	-	-
12	<b>Татварын дараах ашиг (алдагдал)</b>		<b>-1,221.0</b>	<b>-11,205.6</b>
13	<b>Тайлант үеийн цэвэр ашиг ( алдагдал)</b>		<b>-1,221.0</b>	<b>-11,205.6</b>
14	<b>Орлогын нийт дүн</b>		<b>-1,221.0</b>	<b>-11,205.6</b>

**“ЦАГААН ТОЛГОЙ” ХК****2020 оны 12-р сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн****ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН**

Үзүүлэлт	Өмч	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
<b>2018 оны 12-р сарын 31-ны үлдэгдэл</b>	<b>11,081.3</b>	-	<b>-11,138.8</b>	<b>-57.5</b>
<b>Залруулсан үлдэгдэл</b>	<b>11,081.3</b>	-	<b>-11,138.8</b>	<b>-57.5</b>
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-1,221.0	-1,221.0
Зарласан ногдол ашиг	-	-	-	-
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	-	-	-
<b>2019 оны 12-р сарын 31-ны үлдэгдэл</b>	<b>11,081.3</b>	-	<b>-12,359.8</b>	<b>-1,278.5</b>
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	-
<b>Залруулсан үлдэгдэл</b>	<b>11,081.3</b>	-	<b>-12,359.8</b>	<b>-1,278.5</b>
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-11,205.6	11,205.6
Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-	-
Өмчид гарсан өөрчлөлт	-	-	-	-
Зарласан ногдол ашиг	-	-	-	-
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	-	-	-
<b>2020 оны 12-р сарын 31-ны үлдэгдэл</b>	<b>11,081.3</b>	-	<b>-23,565.4</b>	<b>-12,484.1</b>



**“ЦАГААН ТОЛГОЙ” ХК**

2020 он 12-р сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн

**МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

Үзүүлэлт	2019.12.31 (мян.төг)	2020.12.31 (мян.төг)
<b>Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>	-	-
<b>Мөнгөн орлогын дүн</b>	-	-
Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	-	-
Бусад мөнгөн орлого	-	-
<b>Мөнгөн зарлагын дүн</b>	-	<b>10,552.5</b>
Ажиллагчдад төлсөн	-	9,922.1
Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	-	630.4
<b>Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	-	<b>10,552.5</b>
<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	-	-
<b>Мөнгөн орлогын дүн</b>	-	-
Хүлээн авсан хүүний орлого	-	-
<b>Мөнгөн зарлагын дүн</b>	-	-
Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-	-
<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	-	-
<b>Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	-	-
<b>Мөнгөн орлогын дүн</b>	-	<b>9,249.5</b>
Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	-	9,249.5
<b>Мөнгөн зарлагын дүн</b>	-	-
Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	-	-
<b>Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	-	<b>9,249.5</b>
Валютын ханшийн зөрүү	-	-
<b>Бүх цэвэр мөнгөн гүйлгээ</b>	-	<b>-1,303.0</b>
<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>1,392.0</b>	<b>1,392.0</b>
<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>1,392.0</b>	<b>89.0</b>